



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Үндэсний болон дэд хөтөлбөр, төлөвлөгөөний
2021 оны хэрэгжилтийг тайлагнах хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1, 2 дугаар хавсралт, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг хяналтад авч, хэрэгжилтийг хангах зорилгоор үндэсний болон дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Бодлогын баримт бичгийн холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн боловсруулж, Бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэхийг хуваарьт дурьдсан нэр бүхий албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн хэлтэс /Г.Гантүшиг/-т тус тус даалгасугай.

ДАРГА

С.НЯМДОРЖ



1150600011

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын
даргын 2021 оны 03 сарын 02-ны өдрийн
А/06 дугаар тушаалын хавсралт



ҮНДЭСНИЙ БОЛОН ДЭД ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	Хөтөлбөрийн нэр	Хэрэгжих хугацаа	Тайлагнах хугацаа	Хариуцах хэлтэс, албан тушаал
1	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	2020-2023	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүний нөөц, гэрээ, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн
2	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр	2017-2021	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Бодлогын хэрэгжилт, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн
3	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	2020-2025	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Бодлогын хэрэгжилт, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн
4	"Монгол улсын хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратеги"-ийг хэрэгжүүлэх 2020-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	2020-2023	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Стратеги төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
5	Төрөөс хүн амын хөгжлийн баримтлах бодлогыг хэрэгжүүлэх 2018-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө	2018-2025	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Стратеги төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
6	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2020-2021	2022.01.10	Сургалт судалгааны хэлтэс, Ахлах мэргэжилтэн
7	Нийслэлийн жендерийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр	2020-2025	2022.01.10	Сургалт судалгааны хэлтэс, Ахлах мэргэжилтэн
8	Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр /I үе шат/	2019-2021	2022.01.10	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Хөтөлбөр, төсөл хариуцсан мэргэжилтэн
9	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2019-2022	2022.01.10	Сургалт судалгааны хэлтэс, Сургалт, судалгаа, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
10	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2018-2022	2022.01.10	Сургалт судалгааны хэлтэс, Хөдөлмөрийн харилцаа, зорилтот бүлгийн асуудал хариуцсан мэргэжилтэн
11	Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр	2020-2023	2022.01.10	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Ахлах мэргэжилтэн
12	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр	2017-2021	2022.01.10	Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Хүний нөөц, гэрээ, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн
13	Дэлхийн Монголчууд үндэсний хөтөлбөр	2020-2024	2022.01.10	Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн
14	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2019-2021	2022.01.10	Сургалт судалгааны хэлтэс, Мэдээллийн технологи, хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн
Жич: Хариуцсан албан тушаалтнууд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацааны дагуу жилд нэг удаа тайлагнах бөгөөд холбогдох зорилт, арга хэмжээний гол үр дүнг 1000-1500 тэмдэгтэд багтаан боловсруулна.				

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР